

Хаалтын үг

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Хайрт ах эгч дүү нар аа, бид энэхүү хамгийн сүнслэг, сэтгэл хөдөлгөм чуулганыхаа төгсгөлд ирээд байна. Үг хэлсэн хүмүүсийн заавар, гэрчлэлийг сонссоноор бид асар их адислагдлаа. Бид бүгд Есүс Христийн сайн мэдээний зарчмуудыг дагахдаа илүү шийдвэр төгс байх болно гэдэгт би итгэлтэй байна. Энд байх нь бидэнд сайхан байлаа. Чуулган дээр үг хэлсэн бүх ах эгч нар, түүний дотор залбирал хэлсэн хүн бүрд бид талархал илэрхийлж байна.

Дуу хөгжим үнэхээр сүрдэн бишрэмээр сайхан байлаа. Сургаал ба Гэрээний нэг судар санаанд минь орлоо: “Учир нь зүрх сэтгэлийн дуунд сүнс минь баярлах авай; тийм ээ, зөв шударгыг үйлдэгчийн дуу нь надад хандсан залбирал бөлгөө, мөн энэ нь тэдний тэргүүн дээр адислалаар хариулагдах болно.”

Энэ удаагийн чуулганаар та бидний сонссон захиасууд 5-р сарын Лиахона, Ensign сэтгүүлүүдэд нийтлэгдэнэ гэдгийг хэлье. Эдгээр захиасуудыг уншиж, сургамжуудынх нь талаар тунгаан бодож амьдралдаа хэрэгжүүлээрэй хэмээн та бүхэнд захиж байна.

Та бүхэн энэ чуулганы үеэр дуудлагаасаа чөлөөлөгдсөн ах эгч нарт миний нэг адил талархаж байгаа гэдгийг мэдэж байна. Тэд сайн үйлчилж, Их Эзэний ажилд гайхамшигтай хувь нэмрээ оруулсан юм. Тэд дуудлагат ажлаа маш сайн хийсэн. Бид тэдэнд чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна.

Энэ чуулганы үеэр бид шинэ дуудлага авсан ах эгч нарыг гараа өргөн дэмжсэн билээ. Бид Их Эзэний энэхүү ажилд тэдэнтэй хамтдаа ажиллах болсондоо их баяртай байгааг мэдээсэй гэж бид хүсэж байна.

Ах эгч дүү нар минь, өнөө үед биднийг хүрээлэн буй дэлхий ноцтой бөгөөд санаа зовоосон асуудлуудаар дүүрэн байна. Дэлхий хамгаалалтын зогсоолоос зайлан холдож, энх амгалангийн боомтоос холдон хөвөх усан онгоц лугаа адил болжээ.

Ёс суртахуунгүй явдал, садар самуун, порнограф, шударга бус байдал болон бусад буруу зуршлууд олон хүнийг гэм нүглээс болж зовлонгийн далайд живж, олон боломж, адислалаа алдахад хүргэж байна.

Их Эзэний гэрэлт цамхгийг чиглэн яв гэж би зөвлөж байна. Тэрхүү цамхгийн гэрэл өтгөн манан, харанхуй шөнө, хүчтэй шуурганд төөрсөн далайчныг аварч чадна. Тэр цамхаг амьдралын их шуурган дунд тодоор гэрэлтэнэ. Их Эзэний гэрэлт цамхаг хэзээ ч үл унтрах дохиог илгээсээр байх болно.

“Эзэн бол миний хад, миний цайз, миний аврагч, миний Бурхан, [миний итгэж найдах хүч чадал] . . . Эзэнийг би дуудаад, өөрийн дайснуудаас би [аврагдах болно].”¹ гэсэн Дуулал дахь судрын шүлэгт би дуртай.

Ах эгч дүү нар аа, Их Эзэн бидэнд хайртай. Хэрэв бид Түүнээс хүсвэл Тэр биднийг адислах болно.

Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ болон түүний ачаар та бидний амьдралд ирсэн адислалуудын төлөө бид ихэд талархаж байна. Их Эзэн хүмүүн биднийг асар ихээр адисалсан юм. Энэ ажил үнэн, бидний Аврагч амьд, Тэрээр энэ дэлхий дэх Өөрийн Сүмийг удирддаг гэдгийг би та нарт гэрчилж байна. Чуулган өндөрлөх энэхүү мөчид зүрх минь баяраар бялхаж, сэтгэл догдлон хөдөлж байна. Би та нарт хайртай мөн та нарт ихэд талархдаг. Та бүхэн миний төлөө бас Ерөнхий Мэдэлтнүүдийн төлөө залбирч байсанд маш их баярлалаа. Их Эзэн та бүхний залбирлыг сонсож биднийг адислан, дэлхий дээрх Түүний хаант улсын ажил хэргийг явуулахад биднийг удирдан чиглүүлдэг. Үүний төлөө бид гүн талархалтай байдаг билээ.

Чуулган өндөрлөх энэхүү агшинд, тэнгэрийн адислалууд та нарын хүн нэг бүр дээр ирэхийг би урин дуудаж байна. Та бүхэн дэлхийн өнцөг булан бүрд гэртээ харихад Тэнгэрлэг Эцэг та нарыг болон гэр бүлийг тань адислах болтугай. Энэ чуулганы захиасууд болон сүнс та нарын гэр орон, ажил төрөл, хурал цуглаан дээр, ер нь бүх ажил үйлст тань хэрэгжих болтугай.

Би та нарт хайртай, та бүхний төлөө залбирдаг. Бурхан та нарыг адислаг. Түүний амласан амар амгалан та бүхэнтэй эдүгээ болон үргэлж хамт байх болтугай хэмээн би Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.

Эшлэл

1. Дуулал 18:2, 3